

БАТЛАВ
“ДБЭХС” ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ
Г.ОТГОНБААТАР

ЗАХИРАЛ

БАТЛАВ
“ЖАРААХАЙН БУЛАГ” ХХК-ИЙН
Г.ГЭЛЭГЖАРГАЛ

**ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ
№ ХА/2018/61**

2018 оны 09 дүгээр сарын 05 ны өдөр

Хэрлэн сум

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Нэг талаас “ДБЭХС” ТӨХК /цаашид “Худалдагч” гэх/, нөгөө талаас “Жараахайн булаг” ХХК/цаашид “Худалдан авагч” гэх/ - /цаашид хамтдаа “Талууд” гэх/ нар дараах зүйлийг харилцан тохиролцож 2018 оны 09 дүгээр сарын 05 ны өдөр энэхүү гэрээг байгуулав.

1.2. Монгол Улсын Иргэний хуулийн 243-261 зүйлүүдийг үндэслэнбараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход оршино.

1.3. Худалдагч нь засвараар гарсан хаягдал төмөр, алх /цаашид “Бараа” гэх/-ыг худалдан авагчид нийлүүлэх, худалдан авагч нь нийлүүлсэн барааг хүлээн авч, энэхүү гэрээнд заагдсан нөхцлийн дагуу төлбөрийг хийхээр тохиролцов.

Хоёр. Худалдагчийнэрх, үүрэг

2.1.Худалдагч нь гэрээнд заасан бараа материалыг Дорнод аймаг дахь өөрийн төв агуулахад бэлэн байлгах үүрэгтэй.

2.2.Худалдагч нь бараа материалыггэрээ байгуулагдсанаас хойш 2019 оны 09 дүгээр сарын 05 ны өдрийг дусталх хугацаанд гарсан хаягдал алх, төмрийг цуглуулж нийлүүлнэ.

2.3.Цуглуулсан төмрөөсшаардлагад нийцээгүй төмөр гарсан бол худалдан авагчийн сонгосон хаягдал төмрийнхэмжээгээр тооцно.

2.4.Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг худалдан авагчаас шаардах эрхтэй.

Гурав. Худалдан авагчийн эрх, үүрэг

3.1.Худалдан авагч нь барааг хүлээн авахдаа шаардлага хангасан эсэхийг шалгаж хүлээж авах ба тээвэрлэлтийг өөрсдөө хариуцна.

3.2.Худалдан авагч нь барааны төлбөрийг хоорондын тооцоогоорбарагдуулна.

Дөрөв. Төлбөр тооцоо

4.1.Худалдагчийн нийлүүлсэн хаягдал алх, төмрийн тонн тутмыг 110,000 /Нэг зуун арван мянга/ төгрөгөөр тооцож ДБЭХС/201801078 дугаартай алхан тээрмийн алх нийлүүлэх гэрээний төлбөрөөс суутгана.

Тав. Бусад

5.1. Энэхүү гэрээний явцад гарсан маргааныг талууд харилцан хэлэлцэж шийдвэрлэх ба эсхүл Монгол Улсын шүүх, Монгол улс дахь арбитрын байгууллагаар шийдвэрлүүлнэ.

5.2. Гэрээнд талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр бичгээр үйлдсэн нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд эх хувьд баллаж засварласан буюу гараар нэмж бичсэн болон бусад энгийн аргаар хийсэн аливаа оруулга, засвар, нэмэлт бичилтийг хүчинтэйд тооцохгүй.

5.3. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ХУДАЛДАН АВАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:


САНХҮҮ БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА


Д.ГЭРЭЛЧУЛУУН

ХАНГАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
ДАРГА



А.ТӨГСМАНДАХ

ХӨДӨЛМӨРИЙН ХАРИЛЦАА, ХУУЛИЙН
МЭРГЭЖИЛТАН
А.МЭНДСАЙХАН



ХУДАЛДАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

НЯГТЛАН БОДОГЧ

 Ю.АМАРЖАРГАЛ

Хаяг: Дорнод аймаг, Хэрлэн сум, 1-р баг
“ДБЭХС” ТӨХК-ийн төв байр
Утас: 70584545
Факс: 70584545

Хаяг: Дорнод аймаг, Хэрлэн сум,
1-р баг, “ДБЭХС” ТӨХК-ийн ард
Утас: 99816457, 94213444